

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: ariunzul@mddc.gov.mn
- Холбоо барих утас: 266210 (гар утаснаас залгах бол 51266210)

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс	Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга	1	Төрийн захиргааны удирдах	T3-3	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/08/71-7.СШХ-Хэлтсийн-дарга.pdf	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
2	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтэс	Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга	1	Төрийн захиргааны удирдах	T3-3	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/08/71-10.ШӨНХ-Хэлтсийн-дарга.pdf	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
3	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	1	Төрийн захиргааны удирдах	T3-3	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/08/71-13.СХОХ-Хэлтсийн-дарга.pdf	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
4	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Яамны үйл ажиллагаа, харьяа байгууллагын төсөл хөтөлбөрийн үйл	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	T3-7	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/08/74-21.ХШҮДАГ-Яамны-үйл-		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

			ажиллагааны хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн					ажиллагаа- төсөл- хөтөлбөрийн- үйл- ажиллагаа- хариуцсан- мэргэжилтэн.p df		
--	--	--	---	--	--	--	--	--	--	--

---oOo---